

Сүмийн түүхэн дэх бие даах чадварын жишээ

Мартин Харрис: 1827 онд Иосеф Смит алтан ялтаснуудаас Мормоны Номыг орчуулахыг хичээх явцдаа мөрдлөг хавчлага, ядууралтай тулгарч байжээ. Амжилттай фермийн эзэн Мартин Харрис Иосефын нөхцөл байдлын талаар олж мэдэв. Иосеф Смит—Түүх 1:61–62-ыг уншаад, Мартин Иосеф Смитэд хэрхэн тусалж чадсаныг олж мэд. Сургаал ба Гэрээ 19:26, 34–35; 104:26-г уншаад, Мартин Харрис хэрхэн Их Эзэнд үйлчилж, бусдыг адисалсан өөр арга замуудыг олж мэд. Мартин Их Эзэнд болон бусдад утга учиртай арга замаар үйлчлэх боломжийг олгохуйц санхүүгийн эрх чөлөөнд хүрсэн байсан. Өсвөр насны хүүхдүүд цаашид Их Эзэнд болон бусдад үйлчлэхэд туслах чадвар, боловсрол, боломж бололцоотой болохын тулд одооноос юу хийж чадах вэ?

Эмма Хэйл Смит: Эмма Хэйл Иосеф Смиттэй танилцах үедээ чадварлаг уран уншигч, зохиолч, багш, хөгжимчин байсан. Сургаал ба Гэрээ 25:5–7, 11-ийг уншаад, Их Эзэний Эммад даалгасан үүрэг хариуцлагыг олж мэд. Эммагийн эзэмшсэн чадвар, боловсрол нь Их Эзэнд болон бусдад утга учиртай үйлчлэхэд тусалсан. Өсвөр насны хүүхдүүд цаашид Их Эзэнд болон бусдад үйлчлэхэд туслах чадвар, боловсрол, боломж бололцоотой болохын тулд одооноос юу хийж чадах вэ?

Виллиам В.Фэлпс: Их Эзэн дөнгөж Сүмд хөрвөгдсөн Виллиам В.Фэлпсийг Миссури руу нүүхийг зааварлажээ. Сургаал ба Гэрээ 55:4, 57:11–13-ыг уншаад, Сүмдээ үйлчлэх Их Эзэний Виллиамд өгсөн онцгой даалгавруудыг олж мэд. Сүмийг өдгөө адисалсаар байгаа Виллиам В.Фэлпсийн бичсэн дууллуудыг хайж олохын тулд дууллын ном-дахь “Зохиолч ба хөгжмийн зохиолч” индексийг ашиглана уу. Виллиам Их Эзэнд болон бусдад утга учиртай үйлчлэхэд тус болох чадвар, боловсролтой болсон байв. Өсвөр насны хүүхдүүд цаашид Их Эзэнд болон бусдад үйлчлэхэд туслах чадвар, боловсрол, боломж бололцоотой болохын тулд одооноос юу хийж чадах вэ?

Сүмийн түүхэн дэх бие даах чадварын жишээ

Мартин Харрис: 1827 онд Иосеф Смит алтан ялтаснуудаас Мормоны Номыг орчуулахыг хичээх явцдаа мөрдлөг хавчлага, ядууралтай тулгарч байжээ. Амжилттай фермийн эзэн Мартин Харрис Иосефын нөхцөл байдлын талаар олж мэдэв. Иосеф Смит—Түүх 1:61–62-ыг уншаад, Мартин Иосеф Смитэд хэрхэн тусалж чадсаныг олж мэд. Сургаал ба Гэрээ 19:26, 34–35; 104:26-г уншаад, Мартин Харрис хэрхэн Их Эзэнд үйлчилж, бусдыг адисалсан өөр арга замуудыг олж мэд. Мартин Их Эзэнд болон бусдад утга учиртай арга замаар үйлчлэх боломжийг олгохуйц санхүүгийн эрх чөлөөнд хүрсэн байсан. Өсвөр насны хүүхдүүд цаашид Их Эзэнд болон бусдад үйлчлэхэд туслах чадвар, боловсрол, боломж бололцоотой болохын тулд одооноос юу хийж чадах вэ?

Эмма Хэйл Смит: Эмма Хэйл Иосеф Смиттэй танилцах үедээ чадварлаг уран уншигч, зохиолч, багш, хөгжимчин байсан. Сургаал ба Гэрээ 25:5–7, 11-ийг уншаад, Их Эзэний Эммад даалгасан үүрэг хариуцлагыг олж мэд. Эммагийн эзэмшсэн чадвар, боловсрол нь Их Эзэнд болон бусдад утга учиртай үйлчлэхэд тусалсан. Өсвөр насны хүүхдүүд цаашид Их Эзэнд болон бусдад үйлчлэхэд туслах чадвар, боловсрол, боломж бололцоотой болохын тулд одооноос юу хийж чадах вэ?

Виллиам В.Фэлпс: Их Эзэн дөнгөж Сүмд хөрвөгдсөн Виллиам В.Фэлпсийг Миссури руу нүүхийг зааварлажээ. Сургаал ба Гэрээ 55:4, 57:11–13-ыг уншаад, Сүмдээ үйлчлэх Их Эзэний Виллиамд өгсөн онцгой даалгавруудыг олж мэд. Сүмийг өдгөө адисалсаар байгаа Виллиам В.Фэлпсийн бичсэн дууллуудыг хайж олохын тулд дууллын ном-дахь “Зохиолч ба хөгжмийн зохиолч” индексийг ашиглана уу. Виллиам Их Эзэнд болон бусдад утга учиртай үйлчлэхэд тус болох чадвар, боловсролтой болсон байв. Өсвөр насны хүүхдүүд цаашид Их Эзэнд болон бусдад үйлчлэхэд туслах чадвар, боловсрол, боломж бололцоотой болохын тулд одооноос юу хийж чадах вэ?